

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв
2016 оны 4-р сарын 07

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2016 оны 04 дугаар сарын 07-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нараас гадна дотоод гадаадын сонирхогч талууд тухайлбал Олон улсын санхүүгийн корпораци, Европийн сэргээн босголтын банк, Монгол улсад суугаа Канад улсын Элчин сайдын яам, Пийс Нексус зэрэг олон улсын дөрвөн байгууллагын төлөөллүүд болон Ханбогд сумын Жавхлант багийн зарим малчид Зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцсон. Мөн тус хуралд Малчдын төлөөллийн зөвлөхөөр Оюу толгойн Хяналт ТББ оролцсон болно.

Тус хурлаар Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн 2-р шатны судалгааг хэрэгжүүлэх Олон талт мэргэжлийн шилжээчдийн багийн судалгааны ажлын эхний явцын тайланг хэлэлцэж санал өгөв. Бор овоогийн задгайн шинэ байршил орчмын газрыг тохижуулах, ургамалжуулах талбайг малчдын оролцоотойгоор хэлэлцэж тохирлоо. Ундай голын дагуу нутагладаг малчдын амьжиргааг дэмжих төслийг хамтран боловсруулж, 4 дүгээр сард багтаан Говийн оюу хөгжлийг дэмжих санд явуулахаар тогтов.

Мөн Зөвлөлийн өмнөх хурлаар тохирсны дагуу Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголтын банкны төлөөллүүд банкуудын нийгэм байгаль орчны Гүйцэтгэлийн стандартын талаар танилцуулга хийлээ. Олон улсын хэмжээнд энхтайвныг тогтоох, зөрчил маргааныг эвлэрүүлэх асуудлаар ажилладаг Пийс Нексус сангийнхан өөрсдийн үйл ажиллагааныхаа тухай мэдээллээ хуваалцсан болно.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.